

ЕРӨӨ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

ТАВИН

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
1	1 дүгээр зүйл	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Дугаар 63	“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ” үндэсний өдрийг 2024 оны 05,10 дугаар саруудад зохион байгууллаа. Ойн санг гэрээгээр эзэмшигч ААН, Нөхөрлөлүүдийн эвгээс 11 төрлийн 557ширхэг гоёлын болон жимсний модны суулгацыг иргэд, албан байгууллагуудад нийлүүлэн ажиглаа. Мөн “БТЕГ” ХХК нь 5 төрлийн 670 ширхэг гоёлын болон жимсний модны суулгацыг айл өрхүүдэд тарааллаа. Бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт төр төсвийн 5 байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшидэг 4 ААНгаж, 4 нөхөрлөл хашаа хайсаа засаж 6 төрлийн /Агч, монос, хайлаас, нарс, гүйлс, буйлс/ 350 ш модыг нөхөн тарилт хийж гүйцэтгэлээ. Сум, тосгоны 75 өрхийн 195 иргэн нийт 920 ширхэг гоёлын болон жимсний модны суулгацуудыг хашаандаа тарьж суулгасан.	100%	
2		Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Дугаар 09 зарлиг	1. 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо Төрийн ордонд болсон “Морин хуур”-ын үндэсний анхдугаар чуулганд Соёлын төвийн дарга оролцсон. 2. Ерөө сумын 100 жилийн ойн баярыг тохиолдуулан баяр наадмын нээлтэнд тоглох 100 морин хуурчийг бэлтгэн 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдөр Ерөө сумын 100 жилийн ойн баяр наадмын нээлтэнд тоглуулсан. Мөн эрэгтэй 25, эмэгтэй 25 нийт 50ш морин хуурын иж бүрэн хувцастай болсон.	100%	
Хэсгийн дундаж: 100 хувь					
1в. Улсын Их Хурлын тогтоол					
1	3 дугаар зүйл 5 дугаар зүйл	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 01 дүгээр сарын 05-ны 7дугаар тогтоол 1	“Монгол хэл, монгол бичгийн багш” пэйж группээс зохион байгуулсан. “Эх хэлний эзэд – 1” уралдаанд 5 сурагч ШИМБЕЕ АРР - аар бичих уралдаанд оролцож 116 ангийн сурагч Э.Номуунаа, Э.Мичидмаа нар 2-р шатанд шалгарч Э.Мичидмаа 5-р байранд орсон. “Эх хэлний эзэд – 2” уралдаанд 7 сурагч ШИМБЕЕ АРР - аар бичих- уралдаанд оролцож 116 ангийн сурагч Э.Номуунаа 2-р шатанд шалгарсан. “Эх хэлний эзэд -3” уралдаанд 4 сурагч оролцсон. “Монгол улсын төрийн дуулал”-ыг монгол бичгээр хичээнгүй сайхан бичиж, Монгол хэлний группд байшуулах уралдаанд 16 сурагч	100%	

2	5 дугаар зүйл	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022 оны 06 дугаар сарын 17-ны 36 дугаар тогтоол	<p>орлоцож байна. Үндэсний бичиг соёлын сарын аян зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж, ЗДТГ – 19 ажилтан, 1-р цэцэрлэгийн 15 багш ажилтан, ЕБС -ийн 31 багш ажилтанд тус тус сургалт хийв. Даалгаварт цахим хичээл үзэж тэмдэглэл хөтлөх, “Төрийн дуулал” – ыг хичээнгүй сайхан бичихээр өгч, 14 хоногийн дараа уулзаж зөвлөгөө өгөхөөр боллоо. 6 – р ангийн суралчид үндэсний бичгээр уншиж бичиж сурсан тайлалт өдөрлөгөө хийсэн.</p> <p>Үндэсний бичиг соёл – Номын өдрийг угтан Х.Батхүүгийн “Төрөлх монгол хэл” шүлгийг анги хамт олноороо уран яруу унших уралдаан удирдамжийн дагуу 2024.09.16- ны өдөр сургуулийн урлаг заалтанд зохион байгуулсан. Дархан-Уул аймгийн ОИЦ сургуулийн МХУЗ-н “Орчил” тэнхим, “Бийрийн жим” клубийн багш нартай хамтран хөтөлбөрт үйл ажиллагааг 2024.10.02нд зохион байгууллаа. Үйл ажиллагаанд ОИЦ сургуулийн МХУЗ-ын 9 багш, Ерөө ЕБС-ийн 5 багш оролцож, сайжруулсан хичээл зааж, хэлэлцүүлэг хийж, бийр болон хулсан үзэглэл сургалт явуулж, үзэсгэлэн гаргаж, сургалтын орчинтой танилцсан. 2024 оныг “Үндэсний бичиг, соёлын жиг” болгон зарласантай холбогдуулан Монголчуудын бичиг үсгийн өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг тус сургуулийн 7 - р үеийнхний дунд “СЭГЛЭЛИЙН ХААД” тэмцээнийг зохион байгууллаа. 3 бүлгийн 85 сурагч оролцсон.</p> <p>Соёлын бүтээгч сарын аяны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн албан хаагчдын монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, бүх шатны төрийн албан хэрэгт кирил болон үндэсний бичгийн хэм хэмжээг мөрдүүлж хэвшүүлэх, сурталчлах, түүгээр бахархах, сурч эзэмших үйл ажиллагааг сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын дунд “ҮНДЭСНИЙ БИЧИГ-ҮНЭТ ӨВ” уралдааныг зохион байгуулан явууллаа. Уг уралдаанд сумын ЗДТГ-аар, Эрүүл мэндийн төв, Улсын Төргүүний 1 дүгээр цэцэрлэг, Т.Бамбаагийн ерөнхий боловсролын сургууль зэрэг 4 байгууллагын 12 төрийн албан хаагч оролцлоо.</p>	
			<p>Сумандаа “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт арга хэмжээний нээлттэй зохион байгуулж сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч 21 иргэн оролцлоо.</p> <p>Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа 2024 оны 01-р сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж тус сумаас 4 иргэн цагаан идээ, дарсан ногоо, жимс жимсгэнэ, модон элдлэл, дээл, хантааз зэрэг 28 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 2,660,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>“Ерөөлтэй цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Ерөө сумын Соёлын төвд зохион байгуулагдаж үзэсгэлэн худалдаанд 2 хоршоо 15 иргэн, жижиг дунд</p>	100%

			<p>Үйлдвэрлэл эрхлэгч 52 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 7,840,000 төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>ХХААХҮЯам болон Сэлэнгэ аймгаас зохион байгуулсан "АЛТАН НАМАР-2024" арга хэмжээнд 3 хоршооны 11 иргэн дөршилсэн ногоо болон нарийн ногоо, цэцгий, ааруул зэргийн бүтээгдэхүүнээр оролцож нийт 7,500,000 төгрөгийн худалдан борлуулалт хийсэн. Мөн төрийн банкнаас зохион байгуулсан хамгийн олон бүтээгдэхүүнтэй оролцогч номинацид 1-р багийн ногоочин Г. Сувдмаа шалгарсан.</p> <p>2024 оны байдлаар Улс, аймгийн 5 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 26 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 78 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 20 гэрүй сая төгрөгийн орлого олсон байна.</p> <p>3.6.2 Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдалын нөхөх, ургацын чанар хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор бордоо худалдан авсан тариаланчдад үнийн дүнгийн 30 хувийн буцаан олголтын хүсэлтийг үр тарианы 5 ААН илтгээгээд байна.</p> <p>3.10.1 Тариалангийн талбайг хашлаажуулах, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд энэ онд 1 иргэн 8 га талбайд 3000 ширхэг хайлаас тарьж ойн зурвас байгуулсан байна.</p> <p>3.11.1 Жил бүрийн намрын ургацаас үрийн болон хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Аймгийн ХААК ХХК-д 971,8 тн будаа худалдаалан, өөрийн үрийн нөөцөнд 10 ААН, 2 Иргэн 1847,5 тн будааг түс нөөцлөөд байна.</p>		
3	3 дугаар зүйл	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай	2022 оны 06 дугаар сарын 17-ны 36 дугаар тогтоол	100%	

Хэсгийн дундаж: 100 хувь

1г. Засгийн газрын тогтоол

		<p>Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай</p> <p>2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоол</p> <p>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 448 дугаар тогтоол</p>	<p>2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ, байршилыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 11 сарын 01-ний өдрийн 105 тоот тогтоолыг батлуулсан. Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ байршил зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 03-ны өдрийн 137 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш цахим сүлжээнд зур мэдээллийг байршуулан хүсэлт гаргасан 24 иргэнд 4.78 га буюу 67 сая төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулавд байна.</p> <p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангаж хэт төвлөлийг бууруулах, батлагдсан төсвийг үр дүнтэй, үр ашгтай зарцуулах зорилгоор орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан орон нутгийн төсвөөс санхүүждэг ИТХ, ЗДТГ-аар, Ойн анги, Бугант Захирагчийн албаны төрийн захиргааны ажигчдад үндсэн цалингийн 80 хүртэл хувиар тооцож олгон ажиллагаа. Мөн улсын төсвийн байгууллагын босоо үйлчилдлэлтэй 11 албан хаагчийн нэмэгдэл 25410.2 мянган</p>	90%	100%	
2	1 дүгээр зүйл	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 448 дугаар тогтоол	100%		

			Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоол	Төрийн захиргааны ангилал зэрэглэлийн хувьд: 1. ТЭ-5-ЗДТТ-н дарга 2. ТЭ-7- Байгаль орчны хяналтын улсын байцаагч-3, Хөдөө аж ахуйн төслийн дарга-1, сум дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч-1 3. ТЭ-8 -Төрийн сангийн мэргэжилтэн-1 4. ТЭ-9- Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЖДҮ хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн -3 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.		
3	1 дүгээр зүйл 2 дугаар зүйл	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 128 дугаар тогтоол	Тогтоолын хүрээнд: 1. ТУТ-6-1 албан хаагч 2. ТУТ-7-1 албан хаагч 3. ТУТ-9-2 албан хаагч 4. ТЭ-5-1 албан хаагч 5. ТЭ-7-4 албан хаагч 6. ТЭ-8-1 албан хаагч 7. ТЭ-9-3 албан хаагч 8. ТҮМ-7-2 албан хаагч 9. ТҮМ-3-1 албан хаагч 10. ТУ-7-1 албан хаагч 11. ТУ-6-1 албан хаагч 12. ТУ-4-1 албан хаагч 13. ТУ-1-4 албан хаагч тус тус ажиллаж байна. Тогтоолын хүрээнд төрийн албан хаагчдын үндсэн цалинг тогтоосон хэмжээнд нь багтаан сар бүр тогтмол олгон ажиллаж байна.	100%	
4	1 дүгээр зүйл	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 128 дугаар тогтоол	Тогтоолын хүрээнд төрийн албан хаагчдын үндсэн цалинг тогтоосон хэмжээнд нь багтаан сар бүр тогтмол олгон ажиллаж байна.	100%	
5	6 дугаар хавсралт	Журам батлах тухай 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоол	Хурдан морин уралдааны талгаар авах арга хэмжээний тухай 2019 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 57 дугаар тогтоол	Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар Засгийн газраас олгож байгаа бөгөөд мөн сум орон нутгийн зүгээс 40 хувь нийтдээ төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдлийг 80 хувиар тооцон 100 хувь олгож байна. Ерөө сумын Засаг даргын 2024 оны А/15 дугаар Хурдан морин уралдааны хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах тухай захирамж гарган жил бүрийн 11 сарын 01-ий өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хурдан морин уралдааныг хориглож зөвшөөрөлгүй 2 удаагийн уралдааныг тарааж албан ёсны зөвшөөрөлтэй 2 уралдаан зохион байгуулж давхардсан тоогоор 541 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Мөн "Ерөөлт ажнай" Ерөө сумын МСУХ-онд 3 удаа албан бичиг хурдуулсан	100%	
6	3 дугаар зүйл	Хурдан морин уралдааны талгаар авах арга хэмжээний тухай 2019 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 57 дугаар тогтоол	Хурдан морин уралдааны талгаар авах арга хэмжээний тухай 2019 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 57 дугаар тогтоол	Ерөө сумын Засаг даргын 2024 оны А/15 дугаар Хурдан морин уралдааны хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах тухай захирамж гарган жил бүрийн 11 сарын 01-ий өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хурдан морин уралдааныг хориглож зөвшөөрөлгүй 2 удаагийн уралдааныг тарааж албан ёсны зөвшөөрөлтэй 2 уралдаан зохион байгуулж давхардсан тоогоор 541 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Мөн "Ерөөлт ажнай" Ерөө сумын МСУХ-онд 3 удаа албан бичиг хурдуулсан	100%	

			урладагч 17 хүүхэдтэй уулзаж эцэг эхчүүдэд зөвлөгөө зөвлөмж өгсөн.		
7		Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022 оны 02 дугаар сарын 23-ны 81 дүгээр тогтоол	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд суманд 2024 оны 05 дугаар сарын 10-31-ны өдрүүдэд зөвлөн туслах ба ажиллаж 1-р багийн 69 малчин өрх, 2-р багийн 86 малчин өрх, 3-р багийн 65 малчин өрх, нийт 220 өрх айлууд, 445 малчин иргэд, мал бүхий иргэд, Шинэ хоршоо хөдөлгөөний тухай 16 хэсэгт маршрутын даяу багийн дарга болон зөвлөн туслах баг Биелчлэн очиж мэдээлэл хүргэж, гарын авлагуудаар хангаж ажилласан. Сумын хэмжээнд 8 хоршооны нэр баталгаажуулж, улсын бүртгэлд баримт бичгийг бүрдүүлж ажилласнаас 4 хоршоо гэрчилгээжиж байгуулагдсан, 1 хоршоог шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулсан, 3 хоршоо гэрчилгээг гарахаар хүлээгдэж байгаа төлөвтэй байна. Хоршоо байгуулахтай холбоотойгоор 90 малчин өрхөд зөвлөн тусалсан. Байгуулагдсан 11 хоршооноос 8 хоршоо нь нийт 740 сая төгрөгийн санхүүжилтийг аваад байна.	90%	
8	2-р зүйл	Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 118 дугаар тогтоол	Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2024 оны 01 дүгээр сараас 05 дугаар сарын хугацаанд 2 ногоочин өөрийн тарьж ургуулсан стандартын шаардлага хангасан 5 төрлийн 6,2 тн хүнсний ногоог дотооддоо борлуулан урамшуулалд хамрагдсан байна. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд сармис-300 кг, сонгино-1000кг, шар лууван-10 кг, шар манжин-6 кг, хүрэн манжин-10кг, урт сонгино-1 кг, байцаа-10 уут, хүлэмж хэмх-10 уут, бөөрөнхий сонгино-1 кг нийт 9 төрлийн хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 1, 2, 3-р багийн 287 иргэнд олгон тариаглалт хийгдээд байна.	100%	
9	3-р зүйл		Номын сангаас "Угийн бичиг хөтлөх" талаар байгууллагын нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. •Угийн бичиг хөтөлдөг иргэдээс өрхийн угийн бичиг хөтлөлт, өөрсдийн угийн бичгийг хэрхэн хөтөлдөг, ямар ач холбогдолтой талаар 1 малчин, 1 сэхээтэн бүхий 2 тэр бүлийг сонгон Соёлын төвтэй хамтран ярилцлага хийж цахим мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан нийтэд түгээн ажилласан ба нийт үзэгчдийн хандалт нийт 9,6К /9600/ хүнд хүрсэн байна. •Номын сангаас "Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол"-ын талаарх 45ш боршур, "Угийн бичиг хөтөлцөгөө" сэдэвт угийн бичгийн талаарх товч мэдээллийг агуулсан 40ш боршур нийт 85 ш боршурыг номын сангаар үйлчлүүлж буй иргэдэд тараасан. •Сумын ЗДТГ-аас Угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн захирал Б.Дүнгээг урьж авчран зохион байгуулсан "Угийн бичиг хөтлөх сургалт, дадлага"-ийн сургалтад 3 албан хаагч хамрагдсан.	100%	
10		Журам шинэчлэн багтах тухай /УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ ЖУРАМ/ 2007 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 257 дугаар тогтоол		90%	

			<p>Номын сангаас үгийн бичгийн талаар цахимаар 3 удаа "Сэлэнгэ Ерөө Соёлын төв" фэйсбүүк хуудсанд мэдээлэл хүргэн ажиллалаа. Уг мэдээлэл 156 хүний хандалттай байлаа.</p> <p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг Засаг даргын Тамгын газрын болон төр, төсвийн байгууллагын ажилтан албан хаагчдад жижиг ном хэлбэрээр хэвлэн 58 албан хаагчдад хүргэсэн.</p> <p>Мөн төр, төсвийн байгууллагууд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог 3-5 гишүүнтэй байгуулан үйл ажиллагаагаа тогтмол явуулан ажиллаж байна.</p> <p>"Төрийн албан хаагчдын зөвлөгөөн-2024" арга хэмжээг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 133 төрийн албан хаагчдыг хамруулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн талаарх мэдлэг мэдээллийг олголоо.</p> <p>Сумын ЭДТГ-н ёс зүйн дэд хороо нь нийт төсвийн байгууллагуудын ёс зүйн дэд хорооны судалгаа мэдээллийг нэгтгэн гаргаж 2024 онд 4 удаагийн хурал, 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Ёс зүйн дэд хороонд 1 өргөдөл гомдол ирснийг өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах арга хэмжээг тус тус авч ажилласан.</p> <p>Тайлант онд сахилгын болон ёс зүйн зөрчил гарган харууцлага тооцуулсан 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулаад байна.</p>		
11	1 зүйл	"Дүрэм батлах тухай" 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол		90%	

ХЭСГИЙН ДУНДАЖ: 96.3 ХУВЬ
НИЙТ ДУНДАЖ: 99 ХУВЬ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:
ТАЙЛАН ГАРГАСАН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН



С.ЦЭВЭЛМАА
Б.ДАШДЭЛЭГ